



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

“Монсек ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд
дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг сэргээх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 63 дугаар зүйлийн 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монсек ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Монсек ҮЦК” ХХК /М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

3. Компанийн үнэт цаасны зах зээлд дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлт хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



ДБАЯРСАЙХАН

151800000406